


**ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



**ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ**

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД**



**ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)**

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 1.7%, 2023 онд: 4.9%  
Инфляци: 2022 онд: 14.7%, 2023 онд: 11.6%

Урсгал тэнцэл: 2022 онд: -19.5%, 2023 онд: -16.8%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2022 оны тайланд прогнозыг хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 2.5%  
Инфляци: 2022 онд: 14.8%


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: -20.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА**

**Төсвийн тэнцэл 10-р сарын байдлаар 1018.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 21.7 хувиар өссөн бол, зарлага 14.6 хувиар өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1018.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 34.2 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 112.80 төгрөгөөр өсжээ.**

Аравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 520.93 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 112.80 төгрөгөөр өсөж 3369.90 төгрөг болов. 10-р сард гадаад валютын нөөц 2.7 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 3.67 хувиар өсөж оны эхнээс 36.19 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 33.69 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



**Инфляцын түвшин 14.5%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 10-р сарын байдлаар өмнөх сараас 1.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар, оны эхнээс 10.9 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 18.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 17.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




**Гадаад худалдааны тэнцэл 2863 сая.ам долларын ашигтай гарав.**

2022 оны аравдугаар сард нийт барааны эргэлт 17.154 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 30.2 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 33 хувь, импорт өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 2863 сая ам.долларын ашигтай гарав.



## 10-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

Нийт хадгаламж 2022 оны 10-р сард 17 их наяд төгрөг болж өмнөх сараас 95.3 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 9.5 хувиар буюу 478.6 тэрбум төгрөгөөр буурав. Тус сард төгрөгийн хадгаламж 12444 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 1 хувиар буурч, валютын хадгаламж 4642 тэрбум төгрөг болж өмнөх сараас 0.6 хувиар нэмэгдэв. Үүнээс төгрөгийн хадгаламж 73 хувь, валютын хадгаламж 27 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 16.5 хувиар буурсан бол валютын хадгаламж 16.8 хувиар нэмэгджээ.

## САРЫН ОНЦЛОХ

**УЛСЫН ГАДААД ӨР ЭНЭ ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД 33.3 ТЭРБУМ АМ. ДОЛЛАР БОЛОВ**

- Улсын нийт гадаад өр энэ оны эхний хагас жилд 33.3 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеийнхээс 271.5 (0.8 хувь) сая ам.доллаар нэмэгдэж, өмнөх улирлынхаас 545.1 (1.6 хувь) сая ам.доллаар багассан байна. Нийт гадаад өрийн 12.1 (36.5 хувь) тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг, 9.2 (27.6 хувь) тэрбум ам.доллар нь бусад салбарынх, 8.1 (24.2 хувь) тэрбум ам.доллар нь Засгийн газрынх, 2.5 (7.5 хувь) тэрбум ам.доллар нь Төв банкных, 1.4 (4.2 хувь) тэрбум ам.доллар нь Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагын аж. Улсын нийт гадаад өр энэ оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг 156.3 (1.3 хувь) сая, бусад салбарынх 470.3 (5.4 хувь) сая, Төв банкных 244.7 (10.9 хувь) сая ам.доллаар нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагынх 191.5 (12.1 хувь) сая, Засгийн газрын гадаад өр 408.6 (4.8 хувь) сая ам.доллаар багассан.

**ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ 15 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЭХЭЭР БАЙНА**

- Үүний 61 хувийг төрөөс олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 15 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 12 хувийг бусад салбарын цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, 8 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 4 хувийг төрөөс иргэн, аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлт, татаас эзэлж байна. Олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн хямралт нөхцөл байдал 2024 он хүртэл үргэлжилнэ гэж төсөөлж буй энэ үед төр хэмнэлт хийж, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан, макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатайг төсвийн төсөлд тэмдэглэжээ.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 10-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 10-р сар 2022 он, Монголбанк
- [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)